

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-4

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 5-20

1.Дэд хорооны даргыг сонгох тухай асуудал 6-7
/үргэлжлэл/

2.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон 7-15
Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн
тайлан

3.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын 15-20
хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай/

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 10 дугаар сарын 29-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Х.Ганхуяг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 49 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Даваасүрэн, Б.Мөнхсоёл;
Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Ж.Баясгалан, Х.Булгантуяа, Ж.Ганбаатар, Ч.Номин, Г.Тэмүүлэн, Д.Энхтүвшин.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, Ж.Батсуурь нар үг хэлж, Байнгын хорооны дарга Х.Ганхуяг хариулж, тайлбар хийв.

Нэг.Дэд хорооны даргыг сонгох тухай асуудал /үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа нар байлцав.

Байнгын хорооны дарга Х.Ганхуяг Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатарыг Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргад нэр дэвшүүлсэн талаар танилцуулав.

Нэр дэвшигчээс болон танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Х.Ганхуяг: Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатарыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Х.Ганхуяг Байнгын хорооны тогтоолыг уншиж танилцуулав.

Уг асуудлыг 12 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батцэцэг, мөн газрын ахлах шинжээч Ш.Бумаажав, референт Д.Даваасамбуу, Үнэлгээ, мониторингийн хэлтсийн дарга Б.Баярсүх, Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ, мониторингийн газрын дарга Б.Алтантуяа, мөн газрын референт Ч.Сарантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа нар байлцав.

Тайланг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батцэцэг танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайхан, Г.Ганбаатар нарын тавьсан асуултад Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батцэцэг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар үг хэлэв.

Уг асуудлыг 13 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа нар байлцав.

Байнгын хорооны дарга Х.Ганхуяг тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Х.Ганхуяг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, П.Мөнхтулга, Б.Түвшин нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэн нууц санал хураалт явуулах горимын санал гаргав.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	12
Бүгд:	18

33.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 19
Бүгд: 20
55.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 8
Бүгд: 20
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр уг асуудлыг хэлэлцэхийг хойшлуулах горимын санал гаргав.

Х.Ганхуяг: Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярыг бүрэлдэхүүнээс хасаж, Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааныг оруулах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 11
Бүгд: 20
45.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Х.Ганхуяг: Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулгыг бүрэлдэхүүнээс хасаж, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшинг оруулах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 11
Бүгд: 20
45.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны дарга Х.Ганхуяг 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар, Да.Цогтбаатар нар нэрээ татсан тухай мэдэгдэв.

Байнгын хорооны дарга Х.Ганхуяг “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолыг танилцуулав.

Уг асуудлыг 13 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 54 минут үргэлжилж, 29 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 69.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 43 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Х.ГАНХУЯГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
12 цаг 49 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Х.Ганхуяг: Байнгын хорооны гишүүд энэ өдрийн мэндийг хүргэе. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 51.7 хувь буюу Тилеуханы Аубакир, Жамбын Батсуурь, Пүрэвжавын Ганзориг, Батжаргалын Заяабал. Орчихсон байгаа юм биш үү. Даваагийн Цогтбаатар, Далайн Батбаяр, Хөххүүгийн Болормаа, Хассуурийн Ганхуяг, Даваахүүгийн Пүрэвдаваа, Ренчиндоржийн Батболд. Тэгээд одоо яана гэсэн үг юм бэ?

Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 51.7 хувь буюу Тилеуханы Аубакир, Жамбын Батсуурь, Пүрэвжавын Ганзориг, Батжаргалын Заяабал, Банзрагчийн Түвшин, Далайн Батбаяр, Хөххүүгийн Болормаа, Хассуурийн Ганхуяг, Пүрэвбаатарын Мөнхтулга, Даваагийн Цогтбаатар, Ренчиндоржийн Батболд, Гомбын Ганбаатар, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Даваахүүгийн Пүрэвдаваа, Доржсүрэнгийн Үүрийнтуяа нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Ирээгүй байгаа гишүүд Жуковын Алдаржавхлан, Жадамбаагийн Баясгалан, Цэрэнпилийн Даваасүрэн, Чинбатын Номин, Баттогтохын Чойжилсүрэн, Норовын Алтанхуяг, Хүрэлбаатарын Булгантуяа, Загджавын Мэндсайхан, Пүрэвжавын Сайнзориг, Дашцэрэнгийн Энхтүвшин, Жигжидийн Батжаргал, Жамбалын Ганбаатар, Баатаржавын Мөнхсоёл, Ганзоригийн Тэмүүлэн нарын гишүүд ирээгүй байна.

Ирц бүрдсэн. Өнөөдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг сонгох тухай асуудал.

2.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан хэлэлцэнэ.

Мөн Ардчилсан намын бүлгээс төсвийн ажлын хэсэгт өөрчлөлт оруулах тухай хүсэлт тавьсан байгаа. Энийг одоо Даргын дэргэдэх зөвлөл дээр зөвшөөрөл авч байж тов дараалалд оруулна. Тэгээд тийшээ хүсэлтээ явуулчихлаа. Хэрэв зээ одоо амжаад ирвэл хэлэлцэх асуудалд оруулна гэсэн үг.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу?

Цогтбаатар гишүүнээр тасаллаа. Цогтбаатар гишүүний микрофоныг өгчих.

Да.Цогтбаатар: Төсвийн байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ хэлэлцэх асуудал дээр зарим Байнгын хорооны бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтойгоо холбогдуулаад одоо Зарлагын хяналтын дэд хороон дээр Ардчилсан намаас Мөнхтулга гишүүний нэр орох албан бичиг одоо Төсвийн байнгын хороонд ч очсон байгаа байх, Их Хурлын даргад ч очсон байгаа байх. Энэ асуудлыг хэлэлцээд Зарлагын хяналтын дэд хороон дээр Ардчилсан намаас Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүнийг нэмж оруулах асуудлыг энд хэлэлцэж өгнө үү гэдэг ийм санал байна.

Х.Ганхуяг: Энэ дээр ийм байгаа шүү. Мөнхтулгыг нэмэх гэхээр нөгөө харьцаанд өөрчлөлт орчих гээд байгаа юм. Тэгээд манай намаас бас 1 хүн дэвшүүлэх хэрэгтэй болчихоод байгаа юм. Манайх ч, айн? Ирээгүй байгаа юм уу? Ардын намын бүлгээс бичиг ирэх ёстой юм. Ардын намын бүлгийн бичиг ирээгүй байгаа юм. Харин тэгээд тэр нь.

Батсуурь даргын микрофоныг өгье.

Ж.Батсуурь: Байнгын хорооны гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Өнгөрсөн гурав дахь өдрийн Төсвийн байнгын хороонд манай ажлын албанаас ирсэн санал цагтаа ирж, ирсэн боловч хэлэлцэгдээгүй өөр санал хураагдсан байна аа гэсэн асуудал байгаа. Тэгээд энийг залруулж хэлэлцэж өгнө үү гэсэн санал байна.

Х.Ганхуяг: Одоогийн байдлаар дэмжигдээгүй байна. 1 хүний санал өгөгдсөн байна. Одоо хүлээж байгаад энэ санал орчих юм бол, дараа нь дэмжигдчих юм бол шууд хэлэлцээд явчихъя тэгэх үү? 2 асуудлаа хэлэлцэж дууссаны дараа Даргын дэргэдэх зөвлөл дээр дэмжигдчих юм бол хэлэлцээд явчихъя аа гээд. Асуугаад явуулчихлаа. Бейсен гишүүн дэмжээд өгсөн байна. Өөр хүн, гишүүн алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг сонгох тухай асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.10-д Дэд хорооны даргыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар гишүүдийн олонхын саналаар сонгох бөгөөд Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг цөөнхийн бүлгийн гишүүдээс, хэрэв цөөнхийн бүлэг байгуулах гишүүдийн тоо хүрэхээргүй бол цөөнхийн гишүүдээс сонгоно гэж заасны дагуу Төсвийн байнгын хорооны 10 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатарыг Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргад нэр дэвшүүлэх талаар Ардчилсан намын бүлгээс ирүүлсэн албан бичиг та бүхэнд танилцуулсан. Нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатарын намтрыг уншиж танилцуулъя.

Бууч овогт Даваагийн Цогтбаатар нь 1985 онд Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлэгт Даваагийн бага хүү болж төрсөн. 1993 он хүртэл эцэг эхийн гар дээр болон цэцэрлэгт хүмүүжсэн. 1993-2003 онд Баянхонгор аймгийн 10-н жилийн 2 дугаар сургуулийг, 2007 онд СЭЗДС-ийг Санхүүч мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн. 2025 онд БНХАУ-ын Renmin Ардын Их сургуулийн магистр, 2007-2012 онд Голомт банк, 2012-2015 онд Баянхонгор аймгийн Голомт банкны захирал, 2016-2020 Монгол Улсын Хөгжлийн банканд ахлах мэргэжилтэн, хэлтсийн захирал, 2021-2022 онд Хаан банкны салбарын удирдлагын газрын захирал, 2022 оноос

Халамжийн даатгалын корпорац газрын захирлаар, 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна. Эхнэр 3 хүүхдийн хамт амьдарч байна.

Нэр дэвшигчээс асуулт асуух гишүүн байна уу?

Асуух асуулт гишүүд нь алга байна.

Санал хураалтад бэлдье.

Нэр дэвшигчийн талаар үг хэлэх гишүүн байна уу?

Байхгүй.

Санал хураалт. Алив ирц ээ хараадахъя даа. Мөнхтулга гишүүнийх ороогүй байна. Батболд гишүүн ирсэн юм уу? Батбаяр гишүүн ороогүй байна. Заяабал гишүүн ороогүй байна. Мөнхтулга гишүүн орсон байна. Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатарыг сонгохыг дэмжсэн тул “Дэд хорооны даргыг томилох тухай” Байнгын хорооны тогтоолыг та бүхэнд уншиж танилцуулъя. Байнгын хорооны тогтоолыг.

Байнгын хорооны тогтоолыг баталсанд тооцон Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг сонгох асуудлыг хэлэлцэж дууслаа.

12.58 цаг

2.Хууль тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэж эхэлье.

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журмын дагуу Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас хууль, Улсын Их Хурал болон Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний тайланг та бүхэнд хүргүүлсэн.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалуудыг танилцуулъя.

Батцэцэг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга. Ажлын хэсэг оруулаарай. Баярсүх Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн хэлтсийн дарга, Бумаажав Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын ахлах шинжээч, Даваасамбуу Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын референт.

Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан, танилцуулгыг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Батцэцэг танилцуулна. Ажлын хэсгийн 6 дугаар микрофон уу? 6 дугаар микрофоныг өгье.

Б.Батцэцэг: Улсын Их Хурлын Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.9, 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалт болон Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4-д заасныг үндэслэн Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан байгууллагын үйл ажиллагаа үр дүнг үнэлж дүгнэх журмын 3.7-д заасан аргачлалыг баримтлан Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний үр дүнг танилцуулж байна.

Засгийн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний сан new.unelgee.gov.mn-д Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол болон Байнгын хорооны нийт 238 тогтоолын 1044 заалт бүртгэлтэй байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар хууль, Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын Байнгын хорооны шийдвэрийн хэрэгжилт дунджаар 46 хувьтай үнэлэгдлээ.

Тухайлбал, Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим системд бүртгэлтэй байгаа Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийг төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын харьяа агентлаг, аймаг, нийслэлийн төрийн захиргааны байгууллагаар авч үзэхэд 1044 заалтаас 40.6 хувь буюу 424 нь хэрэгжсэн, 47.7 хувь буюу 498 нь хэрэгжээгүй, 11.7 хувь буюу 122 заалт хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй гэж үнэлэгдсэн байна.

Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим бүртгэлд, цахим санд бүртгэж, хяналтад авсан хууль, Их Хурлын тогтоол, Байнгын хорооны шийдвэрийн хэрэгжилтийн дундаж өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 24.7 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам, 2025 оны 5 дугаар сарын 1-нээс хүчингүй болсон журамд заасан аргачлалаар хэрэгжих шатад буюу 70 хувь, 50-90 хувийг нь бид нар ингэж тооцдог байсан. Хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувь гэсэн ангилалд хамаарах заалтууд шинэ тогтоолоор буюу 2025 оны 43 дугаар тогтоолоор хэрэгжээгүй ангилалд хамаардаг болсонтой мөн холбоотой байна.

Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Шадар сайдын ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын харьяа агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хууль, Их Хурлын тогтоол, Байнгын хорооны шийдвэрийн нийт 66 шийдвэрийн 166 заалт давхардсан тоогоор бүртгэлтэй байгаагаас 41 хувь буюу 68 нь хэрэгжсэн, 45.2 хувь буюу 75 нь хэрэгжээгүй, 13.9 хувь буюу 23 нь хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй гэж тус тус үнэлэгдлээ. Ингээд дунджаар 47.6 хувьтай үнэлэгдсэн байна.

Хуулийн хэрэгжилтийн хувьд авч үзэхэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар Шадар сайдын Ажлын алба, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар болон төрийн захиргааны төв байгууллагын эрхлэх асуудлын хүрээний 78 хуулийн 389 заалтын хэрэгжилтээс авч үзэхэд дунджаар 43.6 хувьтай хэрэгжүүлсэн. Үүнээс онцгой байдлын асуудал эрхэлсэн Шадар сайдын Ажлын алба, Эрчим хүчний яам, Батлан хамгаалах яам хамгийн өндөр буюу 78.6-100 хувьтай байхад Эрүүл мэндийн яам, Сангийн яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамдын хамгийн бага буюу 17-гоос, 17.7-26.7 хувьтай үнэлэгдлээ.

Дээрх хуулийн хэрэгжилтийг давхардсан тоогоор 389 заалтаар Байнгын хороо тус бүрээр авч үзэхэд дунджаар 42.8 хувьтай байна. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний 3 хуулийн 5 заалтын хэрэгжилт хамгийн өндөр буюу 80 хувьтай байгаа бол Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд 3 хуулийн давхардсан тоогоор 19 заалтыг төрийн захиргааны төв 11 байгууллага дунджаар 42.9 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Үүнээс 31.6 буюу 6 заалт хэрэгжсэн, 42.1 хувь буюу 8 заалт хэрэгжээгүй, 26.3 хувь буюу 5 заалтыг хэрэгжүүлэх хугацаа болоогүй гэж тус тус үнэлэгдсэн байна.

Их Хурлын тогтоолын хэрэгжилтийн хувьд авч үзвэл Байнгын хороо тус бүрээр авч үзэхэд дунджаар 51.9 хувьтай үнэлэгдсэн. Үүнээс нийт заалтын 43.4 хувь буюу 291 нь хэрэгжсэн, 40.3 хувь буюу 270 нь хэрэгжээгүй, 16.3 хувь буюу 109 заалтын хэрэгжих хугацаа болоогүй гэж дүгнэгдсэн.

Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хяналт шинжилгээ, үнэлгээний цахим системд бүртгэгдсэн 10 шийдвэр давхардсан тоогоор 93 заалтын хэрэгжилт төрийн захиргааны төв байгууллагын 15 байгууллага дунджаар 54.3 хувьтай байна. Үүнээс 47.3 хувь буюу 44 заалт хэрэгжсэн, 39.8 хувь буюу 37 заалт хэрэгжээгүй, 12.9 хувь буюу 12 заалтыг хэрэгжүүлэх хугацаа болоогүй гэж дүгнэгдсэн.

Байнгын хорооны шийдвэрийн хэрэгжилтийн хувьд хагас жилийн, 2025 оны хагас жилийн байдлаар Их Хурлын 7 Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд дангаараа 66 тогтоол, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороод хамтран 1 тогтоол гаргасан байна. Дээрх нийт 67 тогтоолын 270 заалтын хэрэгжилт Байнгын хороо тус бүрээр авч үзэх юм бол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан тогтоол бүрэн хэрэгжсэн. Төсвийн байнгын хорооны 67 шийдвэрийн 270 заалтын хэрэгжилт дунджаар 56.7 хувьтай, 5 хувьтай үнэлэгдсэн.

Улсын Их Хурлын Байнгын хорооны 67 тогтоолын давхардсан тоогоор 538 заалтыг Шадар сайдын Ажлын алба болон Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, төрийн захиргааны төв байгууллага, 19 байгууллага дунджаар 56.3 хувьтай хэрэгжүүлсэн. Үүнээс 48.7 хувь буюу 262 заалт хэрэгжсэн, 37.5 хувь буюу 202 заалт хэрэгжээгүй, 13.8 хувь буюу 74 заалтыг хэрэгжүүлэх хугацаа болоогүй гэж дүгнэгдсэн.

2025 оны эхний хагас жилийн байдлаар Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд 1 тогтоол, давхардсан тоогоор 47 заалтын хэрэгжилт яамдад дунджаар 32.6 хувьтай байлаа. Үүнээс 29.2 хувь нь буюу 14 заалт хэрэгжсэн, 60.4 хувь буюу 29 заалт хэрэгжээгүй, 8.3 хувь буюу 4 заалт хэрэгжих хугацаа болоогүй гэж үнэлэгдсэн.

Энэхүү үнэлгээний тайланг дүгнэн үзэхэд Улсын Их Хурлын Тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний системд 2016-2025 онд Монгол Улсын хуулиар Засгийн газарт үүрэг, чиглэл болгосон нийт 161 хуулийн 756 зүйл, заалт, Улсын Их Хурлын 163 тогтоолын 914 заалт, Байнгын хорооны 114 тогтоолын 916 заалт, нийт 438 шийдвэрийн 2586 заалтын хэрэгжилтэд хяналт тавьж байгаа тухай 2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр албан бичгээр Хэрэг эрхлэх газарт ирүүлсэн байна.

Үүнээс Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд 13 хуулийн 64 хэсэг, заалт, Их Хурлын 25 тогтоолын дангаар буюу хамтран хэрэгжүүлэх 158 заалт, Байнгын хорооны 1 тогтоолын 32 заалт буюу нийт 39 шийдвэрийн 235 заалт хяналтад байгаа талаар ирүүлсэн.

Гэтэл Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим систем Төсвийн байнгын хороонд 3 хуулийн 4 хэсэг заалт, Их Хурлын 10 тогтоолын 43 заалт, Байнгын хорооны тогтоолын, 1 тогтоолын 10 заалт хяналтад байна. Энэ нь улсын хэмжээнд бүртгэлтэй хяналтад авсан эрх зүйн акт, түүний хэсэг, заалтын нэгдсэн бүртгэл нэгдсэн байдлаар байхгүй, систем хооронд интеграци хийх боломжгүй байгаатай холбоотой байна.

Мөн Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг, чиглэл болгосон шийдвэр гарсан тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж хяналтад аваагүйтэй холбоотой анхаарч ажиллах шаардлагатай асуудлууд мөн үүсэж байна.

Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системд бүртгэлтэй 238 шийдвэрийн 1044 заалтын хэрэгжилт 46 хувьтай. Харин Төсвийн байнгын хороонд хамаарах хууль тогтоомжийн хэрэгжилт 47.6 хувьтай хагас жилээр үнэлэгдсэн.

Монгол Улсын хуулийн холбогдох заалтаар төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас захиргааны актыг батлан хэрэгжүүлэх эрх олгосон 133 заалтаар журам 89, дүрэм 3, 14 аргачлал, стандарт 4, заалт, жагсаалт 6, шалгуур үзүүлэлт 6, тавигдах шаардлага 3, норматив 2, жишиг 2, бусад 22, нийт 151 баримт бичгийг батлахыг үүрэг болгосон байдаг. Үүнээс Засгийн газар 34, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 16, Боловсролын яам 10, Эрүүл мэндийн яам 10, бусад 18 байгууллага 81 захиргааны хэм хэмжээний актыг баталж мөрдүүлэх чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь захиргааны акт батлагдах үе шатны ажил болох хэрэгцээ шаардлагыг урьдчилан судлах, төсөл боловсруулах үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо хийх, холбогдох байгууллагуудаас санал авах, хэлэлцүүлэг хийх гэх мэт зохион байгуулалтын арга хэмжээг дутмаг авч хэрэгжүүлж байгаатай шууд холбоотой байна.

Энэхүү тайлангийн үр дүнгээр Их Хурлын Тамгын газарт уламжлахад Засгийн газарт үүрэг, чиглэл болсон Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтийг хариуцан тайлагнах байгууллагыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тогтоон цахим системд бүртгэж, тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх, Улсын хэмжээнд хяналтад авсан шийдвэрийн нэгдсэн бүртгэл хөтлөх, Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим систем, Их Хурлын Тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний систем хооронд интеграци хийх боломж нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг.../минут дуусав./

Х.Ганхуяг: 6 номер нэмээд өгчих цаг.

Б.Батцэцэг: Засгийн газрын болон Улсын Их Хурлын Тамгын газрын цахим системд байгаа Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны

тогтоолд кодификац хийж бүрэн хэрэгжсэн цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан, шийдвэрт заасан хугацаа дууссан заалтуудыг хяналтаас хасах асуудлыг шийдвэрлэж холбогдох байгууллагад хүргүүлэх саналуудыг тус тус уламжилж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Ганхуяг: Болчихсон юм уу? Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асуух, үг хэлэх гишүүн байна уу? Нэрсээ өгөөрэй.

Жаргалсайхан, Цогтбаатар, Ганбаатар. Ганбаатар гишүүнээр тасаллаа. Жаргалсайхан гишүүний микрофон өгье.

Д.Жаргалсайхан: Бид хэд одоо бас яг ямар ажил хийгээд суугаад байгаа билээ гэдгийг одоо бас үнэлж байгаа үнэлгээ, дүгнэлт бас сая тайлан бол танилцуулагдаж байна л даа. Тэгээд одоо Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн дүн шинжилгээ хийхэд 23.1 хувьтай л байна л даа. Тэгээд энийг ер нь бид нар юу гэж ойлгох вэ? Одоо хэнээс энэ дүнг бид нар шаардаж, энэ хариуцлагажуулах ёстой вэ? Тэгэхгүй бол хэдүүлээ ингээд нэг дүн яриад л ийм муу дүн гарлаа, ийм ажил муу хийгдэж байна л гээд байдаг. Хариуцлагын асуудал энэ дээр яриадах. Ямар хариуцлага авах юм, ямар нэгэн ажил, албан тушаал хашаад цалин мөнгө аваад энэ чинь ажиллаж байгаа биз дээ? Тэгэхээр энэ хүмүүс дээр хариуцлагын асуудлыг яаж оруулж ирсэн юм? Сая энэ чинь хариуцлагын асуудал ерөөсөө яригдсангүй шүү дээ. Ийм муу дүнтэй, ийм үнэлгээтэй байхад бид нар хариуцлага ярих ёстой. Энэ дээр хариулт өгөөч.

Х.Ганхуяг: 6 номерын микрофон өгье.

Б.Батцэцэг: Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас хууль тогтоомжийн биелэлтийг 2025 оны эхний хагас жилээр дүгнэхэд Төсвийн байнгын хороонд холбогдох заалтуудын хэрэгжилт дунджаар 47.6 хувьтай гарсан. Бид нар Засгийн газрын хуралдаанд танилцуулахад мөн яг хариуцлагын асуудал яригдсан. Өмнө нь бид нар 3 удаа Төрийн нарийн бичгийн дарга нар 3 удаа Засаг дарга нарт Засгийн газрын хуралдаан дээрээс арга хэмжээ авах, авч байсан түүх байдаг юм байна лээ. Энэ удаагийн хувьд бид нар Эрүүл мэндийн яам, Хөдөө аж ахуйн яам, Сангийн яамнуудад холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах талаар албан бичгийг хүргүүлсэн. Хэрэгжилтийг хангуулах талаар Хяналт хэрэгжүүлэх газар хяналт тавьж ажиллана.

Түүнчлэн Засгийн газрын хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс өгсөн үүрэг чиглэл юу байсан бэ гэхээр энэ удаагийн 43 дугаар тогтоол өөрөө нөгөө үр дүнг газар дээр нь очиж хяналт шинжилгээ хийх зохицуулалтыг оруулж өгснөөрөө шинэлэг болсон. Үүнтэй холбоотойгоор Хяналт хэрэгжүүлэх газар, Хэрэг эрхлэх газар хамтраад зарим нэг огт хэрэгжээгүй заалтуудтай холбоотой чиг, үүргээ төрийн захиргааны төв байгууллагууд болон яам, агентлаг, орон нутаг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар хяналт шалгалтын ажил хийхээр төлөвлөөд ажиллаж байгаа.

Хяналт хэрэгжүүлэх газрын хувьд 43 дугаар тогтоолд заасан журмын дагуу тодорхой аргачлалаар үнэлгээ үнэлээд танилцуулна. Цаашид авах арга хэмжээг Засгийн газар шийдвэрлэх ёстой.

Х.Ганхуяг: Хариулт дутуу байна уу? Хариулт болсон уу Ганбаатар гишүүнээ? Жагаа гишүүн, Жагаа гишүүнд микрофонд өгье.

Д.Жаргалсайхан: Тийм, хэдүүлээ бол нэг үнэлгээ, дүгнэлт өгчхөөд л байгаад байна шүү дээ. Тэгээд ажил маань ингээд л юу гэдэг юм ингээд л үргэлжлээд байна. Тэгэхээр хариуцлага яг нэг хүн, энэ хүн ийм хариуцлага алдсан учраас ийм хүмүүс дээр ийм хариуцлагын асуудлыг ийм түвшинд авах ийм бололцоо нөхцөл байна аа гэдгийг та хэд санал юм уу хариулт хэлээч. Тэгэхгүй бол дахиад л нэг үнэлгээ, дүгнэлт ийм гарлаа л гээд л ингээд л хариулт хэлээд байна шүү дээ. Тэрийг чинь сонссон. Мэдэж байна.

Х.Ганхуяг: 6 номерын микрофон өгье.

Б.Батцэцэг: Бид яг энэ Байнгын хорооны хурал дээр үнэлгээ хийсэн ажлаа тайлагнаж байгаа учраас би яг Засгийн газрын бодлого, шийдвэрийн өмнөөс бас бүрэн дүүрэн хариулт өгч чадахгүй байх шиг байна. Бид ямар хуулийн боломж байгаа вэ гэхээр Төрийн албаны тухай хуульд заасан холбогдох хариуцлага тооцох асуудлыг эрх бүхий албан тушаалтанд нь санал, дүгнэлтээ танилцуулсан. Эрх бүхий албан тушаалтан маань буцаад бид нарт ямар хариуцлага тооцсон талаараа мэдээлэл буцаж ирүүлэх л үүрэгтэй байгаа.

Засгийн газрын хуралдаан дээр сайдууд, сайд нар ажлаа эрчимжүүлэх талаар бас ярилцсан. Гэхдээ үүнийг Засгийн газрын гишүүд танд илүү бодитой хариулт өгөх болов уу гэж би бодож байна.

Х.Ганхуяг: Ганбаатар гишүүний микрофон өгье.

Г.Ганбаатар: Өдрийн мэнд. Энэ нээрээ арай байна. Өнөөдөр Улсын Их Хурлын, Улсын Их Хурлаас гарсан хууль болон тогтоолын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл сонсож байна шүү дээ. Тэгээд энэ ер нь л бас юу ч гэх юм бэ дээ. Тэр хуулийн холбогдох заалтын хэрэгжилт 36 хувьтай гэж байна тээ? Шийдвэрийн хэрэгжилтээр яах вэ энэ дунджаар тэр 46.7 хувьтай гээд байгаа юм уу нийт гарсан? Дээрээс нь тэр Эрүүл мэндийн яам, Сангийн яам, Соёл, спорт, аялал жуулчлалын яам 17.7-26.7 хувьтай гэж одоо яаж ажлаа хийхлээр ингэдэг юм? Бид одоо энд хуралдаад хууль гаргаад батлаад байдаг. Ахиад Улсын Их Хурлаас тогтоол гардаг. Үгүй тэгээд шийдвэрийн хэрэгжилт нь ийм байхад яаж ажил явж байсан юм? 17.7-26.7 гээд сая өөрийн чинь мэдээнд гарч байна шүү дээ. Үгүй тэгээд та нар энэнийхээ үр дүнг, хэрэгжилтийг шахааж шаардах сахилга хариуцлага яаж тооцдог юм? Үүнтэй холбоотой 3 асуулт байна. Энэ яг ийм хэтэрхий хангалтгүй ажиллаж байхад ямар арга хэмжээ, сахилга хариуцлагатай холбоотой та нар ямар арга хэмжээ авсан юм бэ гэдэг, нэг.

Хоёрдугаарт нь энэ Улсын Их Хурал болоод энэ Засгийн газрын хяналт шинжилгээний алба энэ хамтардаг, хоорондоо энийгээ нэгтгэдэг, дүгнэдэг юм байна уу?

Гуравдугаарт нь аливаа хууль тогтоомж гараад дагаж гарах журмууд нь гарахгүй байгаа дээр та нар бас дүгнэлт хийдэг үү? Жишээ нь сая 2 хоногийн өмнө хөдөө орон нутагт явж байхад Хатанбулаг сумын малчин ярьж байгаа байхгүй юу. Яг энэ талаар чинь ярьж байсан Төмөрмөнх гээд. Ерөөсөө Улсын Их Хурлаас гарч байгаа энэ наад хууль тогтоомж чинь хөдөөд хэрэгжихгүй байна аа та нар дүгнэлт

хийх цаг болсон байх аа гэж байсан. Яг өнөөдөр 2 хоногийн дараа Төсвийн байнгын хороон дээр энэ мэдээлэл орж ирж байна. Тэгээд энэ чиглэлээр яг юу хийдэг юм? Тэр та нар Засгийн газрынхаа Хяналт шинжилгээ, үнэлгээний газар гэж байдаг байх тийм ээ би нэрийг нь буруу хэлж байж магадгүй. Хуучин Одбаяр толгойлоод байсан шиг санаж байна. Эд нартайгаа уялдаа холбоо яадаг юм, энэ биелэлтээ яаж шаарддаг юм? 17-гоос, 100 хувь байх юмыг 17-26 хувьтай байгаа биелэлтийг яаж та нар ингээд эргэж энэ шийдвэрийн биелэлт, дээрээс нь энэ чинь Улсын Их Хурал чинь үндсэн үүрэг нь хууль батлахаас гадна гаргасан хууль тогтоомждоо хяналт тавих, хэрэгжүүлэх, Засгийн газрыг хянах үүрэгтэй шүү дээ. Энэ 3 асуулт дээр эхлээд хариулт аваадахъя.

Дараа нь бас нэг санал Байнгын хорооны даргад хэлэхэд үгүй ээ нээрээ болохоо байчихлаа. Хөдөө явж байгаад өчигдөр 13:30 гэхэд хуралтай гэхлээр нь Хөдөө аж ахуйн байнгын хороо хуралтай гэхээр нь ирсэн. Ирц хүрээгүй хуралдаагүй. Өнөөдөр 10 цагаас Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хамтарна гэсэн. Ирц хүрээгүй, хуралдаагүй. Одоо 12 цагийнх нь хурал үр дүнгийн биелэлт ярьж байхад нэг ийм юм .../минут дуусав./

Х.Ганхуяг: Хэн хариулах юм? 6 номер.

Б.Батцэцэг: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг илүү үр дүнд суурилсан үр дүнг нь тооцож хяналт шинжилгээ, үнэлгээ хийдэг байх талаар Засгийн газар Их Хурлын түвшинд бид нар бас харилцан хамтын ажиллагаа байгаа, ярьж байгаа. 43 дугаар тогтоол бол яг үндсэндээ үр дүнд суурилсан хяналт шинжилгээ үнэлгээ хийх хамгийн анхны оролдлого. Тэгээд Засгийн газрын тогтоолоор батлаад бид нар энэ хууль тогтоомж, 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын хөгжүүлэх 1 жилийн хөгжлийн төлөвлөгөөг бүгдийг нь 43 дугаар тогтоолоор үнэлсэн. Өмнөх үзүүлэлтүүдээс бүгд буураад ороод ирсэн. Өмнө нь бид нар процесс яваад эхэлчихсэнийг 70 хувиар үнэлээд хэрэгжилт явж байгаа гэж үнэлдэг байсан бол энэ бүгд нолиор үнэлэгдээд ороод ирэхээр магадгүй энэ хэрэгжилтийн үнэлгээ бас бууж орж ирж байгаа юм.

Нөгөө талаасаа бид нар бас харах юм байна. Яагаад гэхээр нөгөө хууль тогтоомжийн үнэлгээ хийнэ гэдэг маань хууль бол тухайн хуулийнхаа зорилго, зорилтыг бүрэн хэрэгжүүлж байна уу гэдэг нь Хууль тогтоомжийн хуулиар 5 жилээр үнэлгээ мониторинг хийдэг байтал бид нар одоо ингээд хагас жил болгоноор тэгээд хууль үнэлэгдсэн, үнэлэгдээгүй асуудлыг бас ярих нь зүй юу зохистой юу, үгүй юү гэдэг асуудлыг Их Хурлын түвшинд Их Хурлын Хяналт шинжилгээний газартай бас харилцан ярьж байгаа. Яваандаа бас сайжрах болов уу гэж бодож байна.

Хангалтгүй биелүүлсэн орон нутаг, Засгийн газрын гишүүдийн эрхлэх асуудлын хүрээний энэ Засгийн газрын төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллагуудын хувьд бидэнд байгаа мэдээллээр Хэрэг эрхлэх газраас чиглэл хүргүүлсэн байгаа. Одоо энэ биелэгдээгүй ажлуудыг биелүүлэх, хэрэгжилтийнхээ явцыг хурдасгах, хэрэгжүүлээгүй шалтгаанаа тодорхой тайлбартайгаар ирүүлэх гээд чиглэл хүргүүлсэн. 11 сарын 15-ны дотор яамд Засаг даргын Тамгын газруудаас мэдээлэл Хэрэг эрхлэх газар дээр ирнэ. Энэ удаагийн хяналт шинжилгээний тайланг Хяналт хэрэгжүүлэх газраас буюу саяын таны хэлсэнчлэн Одбаяр сайдын ахалдаг байсан байгууллага л даа энэ маань тайлагнаж байгаа. Засгийн газрын тухай хуульд 7 дугаар сард орсон

өөрчлөлтөөр дараагийн жилийн тайланг хяналт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас тайлагнаж оруулж ирнэ.

Х.Ганхуяг: Ганбаатар гишүүн тодруулъя.

Г.Ганбаатар: Тодруулга авъя. Дутуу хариулчихлаа. Нэгдүгээрт нь тэр Хууль тогтоомжийн тухай хуулиараа хууль хэрэгжилт 5 жилдээ байдаг юм бол түүнийгээ тэгвэл тэр Улсын Их Хурлын Хяналт шалгалт юу гэлээ сая? Хяналт шалгалтын тухай хуультайгаа яаж уялдуулах гэж байгаа юм? Тэр асуудлуудаа тэгвэл бид нарт тодорхой мэдээлэл өгөх хэрэгтэй.

Хоёрдугаарт нь миний асуусан бас нэг асуулт бол энэ Улсын Их Хурлаас гарсан хуулийг дагаад зайлшгүй гарах журмууд байна. Тэр нь одоо гарах ёстой улсууд нь бас гаргаагүй байна. Жишээ нь Малчны тухай хуулийг дагаж гарах журам нь гараагүйгээс болоод хөдөө, орон нутагт малчид хүлээгээд, дээрээс нь тэр нэг малчны хүүхдийн төлбөрийг даана гэсэн юм байна. Тэр чинь 2024 оны 6 сарын 5-нд гарсан хууль бололтой юм тийм үү? Тэгээд малчдын сан байгуулах, эх үүсвэр байгуулах гээд зөндөө олон юмнууд нь хүлээгдээд байгаа юм байна. Энэ дээр мониторинг хийдэг юм уу та нар, энэ чиглэлээр яг юун ажил хийгддэг юм? Би уг нь түрүүнд бас энийг асуусан шүү дээ. Дутуу хариулаад байх юм.

Х.Ганхуяг: Гүйцэд хариулна шүү. Гишүүдийн асуултад гүйцэд хариулаарай. 6 номер.

Б.Батцэцэг: Гишүүний асуултад хариулъя. Миний асуулт магадгүй нөгөө дутуу байгаад байгаа нь би Засгийн газар шууд төлөөлж хариулах бас эрхгүй учраас тийм санагдаж магадгүй. Тэгэхдээ би аль болохоор бүтэн хариулахыг бодъё. Юуны хувьд, энэ батлагдаагүй журмуудын хувьд Хяналт хэрэгжүүлэх газраас ч тэр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ч тэр холбогдох яамнууд руу яаралтай журмаа баталж хэрэгжүүл гэдэг чиглэлүүдийг байнга өгч байгаа. Үүний мөрөөр яамнууд руу арга хэмжээ авч ирүүл гэдэг чиглэлүүдийг албан бичгээр болон бид нарт дотоод хяналт хэрэгжүүлж байгаа албан хаагчдадаа сургалт, уулзалт хийхдээ байнга өгч байгаа. Сайжрах байх.

Малчны хуулийн хувьд бид нар дөнгөж хяналтад аваад явж байгаа. Тэгэхээр хагас, 2025 оны жилийн эцсийн тайлангаар энэ журам батлагдсан эсэх асуудал нь үнэлэгдэж орж ирэх болов уу гэж бодож байна. Улсын Их Хурал дахь Хяналт шалгалтын тухай хуультай холбоотой бид нар ер нь энэ зөвхөн хууль тогтоомж ч гэлтгүй.../минут дуусав./

Х.Ганхуяг: Гүйцэд хариулчих. 6 номер.

Б.Батцэцэг: Хөгжлийн бодлогын баримт бичгүүд дээр суурь түвшнээ үнэлэх, хүрэх түвшнээ үнэлэхэд статистикийн мэдээллүүд бүрэн гараагүй байдаг гээд хэд хэдэн одоо эргэж харах шаардлагатай асуудлууд байгаа. Бид нар энийг Их Хурлын Тамгын газартай уулзаад засах талаар саналуудаа бас харилцан солилцоод явж байгаа.

Х.Ганхуяг: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Цогтбаатар гишүүнийг нэмчихье. Энэ санал хураалт байхгүй байна. Тэгэхдээ энэ чинь дараа нь нөгөө. Цогтбаатар гишүүний микрофон өгөөрэй.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Шалгалтын ажлын хэсэгт бас талархал илэрхийлье. Асуулт алга байна. Угаасаа гүйцэт асуулгах, хариулах боломж байхгүй техникийн хувьд. Тэгэхээр санал хэлэх гэсэн юм. Шалгалт хамарсан хугацаа бол 2016 оноос 2025 он гээд нэг нам дангаараа засгийн эрхийг бариад жишээлэхэд Улсын Их Хурлаас бол 491 шийдвэр гаргаснаас 221 шийдвэр нь хэрэгжээгүй буюу хэрэгжээгүй хувь нь 45 хувьтай байна. Зөвхөн Төсвийн байнгын хороонд хамаарах нь. Тэгэхээр бид нар одоо яаж гаргаж байгаа шийдвэр, гаргаж байгаа энэ хууль тогтоомж чинь хэрэгжихгүй замхарч болдгийг л харж байгаа нэг жишээ. Энэ тайлан дээр бас дурдчихсан байна. Би зүгээр ганцхан жишээг нь л хэлье. Одоо бид нар чинь нэг автомашиныг төрийн машиныг хэмнэлттэй хэрэглэе, цэнхэр дугаартай унаж хэрэглэе гэсэн хэрэгжилт нь дахиад энэ дээр 70 хувьтай буюу үлдсэн 30 хувь нь дахиад л дарга, цэрэг нь дарга нарынхаа эхнэр, хүүхдийг дэлгүүр, сургуульд нь зөөдөг л ийм л ялгаатай, ялгамжтай байдал. Төрийн албан хаагч жишээлэхэд багш нар ажил хаячихсан цэцэрлэгийн хүүхэдтэй, сургуулийн хүүхэдтэй хүмүүс нь хүүхдээ яах вэ, дээрээс нь өөрийгөө яаж ажлаа хийх вэ гэдэг ийм аймаар бэрхшээл дунд байхад дарга болчихсоноороо нөгөө цэнхэр дугаараа авахгүйгээр авгай, хүүхдээ хааш нь дуртай газар нь зөөнө, төрийн мөнгөөр зөөнө, төрийн бензинээр зөөнө. Хэрэгжээгүй байгаа шалтгаанууд чинь ерөөсөө энд гарч ирээд байгаа байхгүй юу.

Одоо энэ 2024 оны Засгийн газрын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтээр 12-15 их наяд төгрөгийн алдаа дутагдал, зөрчил илэрсэн. Дахиад хариуцлага хүлээсэн хэн ч байхгүй. Та нарынхтай бол бас давхардаж гарч ирэх юм шиг байна миний ойлгож байгаагаар.

Тэгэхээр энэ сая Жаргалсайхан гишүүн бас ярьсан хариуцлага хэн хүлээх юм. Тэгээд өнөөдөр энэ Засгийн газрын хэрэг Хяналт хэрэгжүүлэх газрынхан бид нар саналаа бичиж өгөөд ажил дуусчхаж байна гэж яриад байна шүү дээ. Гэтэл Засгийн газар өөрөө хариуцлага хүлээхгүй буюу дарга нарынхаа цалинг нэмж өгдөг. Дээрээс нь бид нар хариуцлага тооцож чаддаггүй. Дахиад нэг тоо ярья. 2023 оны зөвхөн цалингийн зардал дээр 2.3 их наяд төгрөг байсан 2025 онд 6.3 их наяд буюу өөрчлөлтөд 4 их наяд төгрөг байгаа.

Монгол-Японы эмнэлэг дээр эмч, ажилчдынхаа цалинг нэмэхийн оронд эмч, ажилчдынхаа тоог нэмэхийн оронд захиргааныхаа албан хаагчдын тоог нэмээд захиргааныхаа албан хаагчдын буюу тэр аж ахуй хариуцсан дарга нарынхаа тоог нэмж байгаад цалингийнхаа зардлыг дахиад өсгөөд яваад байгаа байхгүй юу. Энэ мэтчилэнгээр бид нар байгаа онохгүй шийдвэр маш их гаргаж байгаа. Төсвийн тухай хууль бас нэг шийдвэр зөв биз? Тэгтэл байгаа онохгүй энэ мэт зардлуудаа гаргасаар байгаад өнөөдөр багш нарын цалин, эмч нарын цалин, бусад төрийн албан хаагчийн цалин, тэтгэврийн нэмэгдэл, ярьж чадахгүй үргүй зардал 4 их наядаар гаргачхаад сууж байгаа Засгийн газрын бодит байдал. Энийг цаашид анхаарч ажиллахгүй бол үнэхээр болохгүй түвшинд хүрчихсэн байгаа юм. Энэ саналыг хэлэх гэсэн юм.

Х.Ганхуяг: Санал хэллээ.

13.26 цаг

Даргын дэргэдэх зөвлөл дээр тов дараалалд өөрчлөлт оруулах тухай санал дэмжигдсэн тул тогтоолд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэнэ.

Төсвийн байнгын хорооны 2025 оны 22 дугаар тогтоол.

Хэлэлцэх асуудалтай асуудлаар саналтай гишүүн байгаа юу?

Байхгүй байна.

Тогтоолыг та бүхэнд уншиж танилцуулъя.

“Тогтоолын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5-д Байнгын хороо шаардлагатай хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий гишүүдээс бүрдсэн ажлын хэсгийг дангаар буюу хамтран байгуулж, энэ асуудлаар Байнгын хорооны тогтоол гаргана гэж заасны дагуу Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэхэд бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулна.

Дээрх ажлын хэсэг нь Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиудыг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий, мөн 2026 онд төсөвтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Төсвийн байнгын хорооны 2025 оны 22 дугаар тогтоолыг баталсан.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орж байгаа тул дээрх тогтоолд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг та бүхэнд танилцуулъя.

2026 оны төсвийн ажлын хэсгийн гишүүн Батбаяр гишүүнийг хасаад Ц.Туваан гишүүн, Мөнхтулга гишүүнийг хасаад Түвшин гишүүн, дагасан хуулийн ажлын хэсэгт Гомбын Ганбаатар гишүүнийг хасаад Баатархүү гишүүн, Даваагийн Цогтбаатар гишүүнийг хасаад Бейсен гишүүн нарын гишүүнд өөрчлөлт, ийм бүрэлдэхүүнд өөрчлөлт орж байна.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан санал гаргах гишүүн байна уу? Дараарай юун дээрээ дараарай.

Мөнхтулга гишүүнээр тасаллаа. Батбаяр гишүүн микрофонд өгье.

Д.Батбаяр: Энэ өдрийн мэнд хүргэе. Ажлын хэсэгт бол анх орохоор саналаа өгсөн. Ажлын хэсэгт ороод ажиллаж байгаа эхний уулзалтуудаа хийгээд явж байгаа учраас энэ ажлын хэсэгтээ үргэлжлүүлж ажиллах саналтай байна. Тэгээд хэн ч надтай ямар нэгэн байдлаар яриагүй. Тэгээд анхны гарсан ажил нь Байнгын хорооны тогтоолоор бол энэ ажлын хэсэгт ороод явсан байгаад байгаа. Тэгээд төвийн бүсийн төлөөлөл болж анх орсон учраас энэ чигтээ ажлын хэсэгтээ ажиллах тийм саналтай байгаад байгаа.

Х.Ганхуяг: Мөнхтулга гишүүний микрофон өгье.

П.Мөнхтулга: Би энэ журмын нөхдүүдээсээ бас Төсвийн байнгын хорооныхоо гишүүдээс гуйж байгаа юм аа. Та бүхнийхээ ажлын хэсэг дээр маш тодорхой саналуудыг авч ажиллана. Тэгээд Төсвийн байнгын хорооныхоо

гишүүний хувьд ч гэсэн яг энэ ажлын хэсэг дээрээ бас урьд нь нэлээн хичээл чармайлт гаргаад ажиллачихсан юм. Тийм учраас бас энийгээ үр дүнгүй орхичихно гэхээр бас тийм байна. Тэгэхээр намынхаа бодлогыг баримталж ажиллана, улс орныхоо эрх ашгийг бас дээдэлж ажиллана. Тэгээд та бүхэн маань энэ ажлын хэсэгт бас үлдээх талаар бодож үзээч гэж гуйж байгаа юм.

Х.Ганхуяг: Ганбаатар гишүүний микрофоныг өгье.

Г.Ганбаатар: Ажлын хэсэгт уг нь ороод ажиллаж л байсан. Би бол их гуйхгүй л дээ. Гэхдээ ингэхэд ажлын хэсгийг өөрийнх нь ороод ажиллаж байсан хүнийг саналыг нь авахгүйгээр ингээд хасаад шууд Бэйсенг оруулаад ирдэг юм уу яадаг юм? Та нар эндээ ингээд 2, 3 хүн ярьж байснаа шууд ингээд сольчихдог юм уу Байнгын хороон дарга аа? Үгүй нээрээ ингэж болох юм уу? Хүмүүс ажлын хэсэг нь нэлээн өмнө гарчхаад ажиллаад явж байсан чинь гэнэт нэг нэр орж ирээд хэнтэй уулзсаныг чинь би мэдэж л байна л даа. Тэгээд ингээд сольчихдог юм уу? Төрийн ажил чинь ингэж явдаг юм уу?

Х.Ганхуяг: Надаас асуулт асуух шиг боллоо. Танай Ардчилсан намын бүлгээс удаа дараа шаардлага тавиад, бичиг хүргүүлээд, Даргын дэргэдэх зөвлөл дээр санал оруулаад ингээд ийм явж байна. Тэгээд одоо энэ манай Байнгын хорооны ажлын албаны гишүүн охидууд руу хүртэл нэлээн хэмжээний дайралт ирж байна. Цагт нь өгсөнгүй, яасангүй гээд. Тэгээд одоо энэ дээр цөмөөрөө санал хураагаад л шийдэхээс л өөр арга алга. Би одоо аль нэгийг нь оруулъя, аль нэгийг нь больё гэж надад хэлэх асуудал алга байна. Ардчилсан намын бүлгээс ийм нэрс өгөөд байна. Тэгээд санал дэмжигдвэл дэмжигдэнэ, дэмжигдэхгүй бол дэмжигдэхгүй ээ.

Байнгын хорооны тогтоолтой холбогдуулаад санал хураалт явуулна. Гишүүд ээ санал хураалтад бэлдье.

Чойжилсүрэн гишүүний микрофон өгье.

Б.Чойжилсүрэн: Байнгын хорооны гишүүдийнхээ өдрийн амрыг эрье. Наана чинь чөлөөлөгдөх гишүүд нь үлдье гэдэг ийм санал байр суурь илэрхийлээд байна шүү дээ. Тэгэхээр наадах чинь шууд ил хураахгүй одоо.

Х.Ганхуяг: Нууцаар явах уу?

Б.Чойжилсүрэн: Нууцаар явна шүү дээ. Тус бүр, хүн тус бүр дээр нь.

Х.Ганхуяг: За. Манай ажлын албаныхан нууц санал хураалтад бэлдээд нэрсээ бэлдчих. Чойжилсүрэн гишүүний гаргасан нууц санал хураалт явуулах горимын саналыг дэмжиж санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдээрэй. Чойжилсүрэн гишүүний саналаар. Би одоо уг нь Ганбаа гишүүн ээ аягүй их.

Чойжилсүрэн гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Тийм байна. Санал хураалтыг дахиж явуулахаар та бүхний санал хураалт. Нууц, ер нь нууцаар явуулахгүй бол энэ чинь жоохон юутай юм даа, галтай юм даа

тээ. Тийм 2 хүн. 1 юун дээр 2 хүн дэвшүүлчихье тээ. Түвшин гишүүний микрофон өгье.

Б.Түвшин: Энэ ажлын хэсгийг байгуулах тухай асуудал дээр Ардчилсан намын бүлэг бичгээ өгсөн. Тэгээд Ардчилсан намын бүлгийн бичиг цаг хугацаандаа ирсэн байсан ч бичиг ирээгүй гэдэг ийм бас нэг завсрын зай гарснаас учраас ингээд өөр ажлын хэсэг байгуулагдаад Ардчилсан намын бүлэг бичгээ ирүүлсний дараа одоо өнөөдөр ингээд санал хураалт болох гэж байх шиг байна л даа. Тэгэхлээр ерөөсөө одоо энэ ирц чинь бүрдээгүй байна. Дээрээс нь энэ дараа дараагийн хурлууд дээр энэ саналаа хураавал яасан юм бэ? Одоо энэ чинь өөрөө ингээд ийм үл ойлголцол үүсчихлээ шүү дээ. Урьд нь Төсвийн байнгын хорооны хурал дээр энэ ажлын хэсгийг бүр томилохдоо Ардчилсан намын бичгийг үзээгүй учраас ингээд томилчихсон байгаад байгаа. Ардчилсан намын бичиг ирчихсэн учраас одоо бид нарын ирц хүрч байгаа юм уу, үгүй юм уу гэдгээ бас нэг анхаарч үзэж байж санал хураалгавал яасан юм бэ?

Х.Ганхуяг: Гишүүд ирцдээ орчхоорой. Гишүүдийн ирц бол хангалттай хүрч байна. 29 гишүүнээс 20 гишүүн ирсэн байна. Ер нь мэдээлэл өгөхөд өнгөрсөн Байнгын хорооны хурлаар ажлын хэсэг байгуулах тухай тов дараалалд оруулаад, санал хураалт явсны дараагаар тэр албан бичиг нь ирсэн шүү. Тийм учраас тухайн Байнгын хорооноосоо шийдээд нэрсээ батлаад явсан байгаа.

Тэр саяын Чойжилсүрэн гишүүний гаргасан горимын саналаар нууц санал хураалт явуулна. Санал хураалтдаа бэлдээрэй. Тийм нууцаар санал хураалт явъя гэдэг дээр. Гишүүдээ санал хураалтад бэлдээрэй. Нууцаар санал хурааа аа гэдэг дээр санал хурааа гэж байна. Үгүй сая ирц гишүүд орж ирээгүй байсан болохоор санал хураалт явуулсан байхгүй юу. Гишүүд санал хураалтад бэлдээрэй.

Саяын саналыг хүчингүйд тооцохоор санал хураах юм байна. Гишүүд санал хураалтад бэлдээрэй. Санал хураалт.

20 гишүүнээс 11 гишүүн дэмжсэн тул нууц санал хураалт явуулах горимын саналыг санал хураалт явуулъя. Чойжилсүрэн гишүүний саналаар. Саяын санал хүчингүйд тооцлоо.

Одоо нууц руу орох уу гэдэг санал хураалт.

Батбаяр гишүүний микрофон өгье.

Д.Батбаяр: Горимын санал гаргах гэсэн юм. Яагаад вэ гэхээр одоо орж ирж ахиад энэ ажлын хэсэгт орох гээд байгаа гишүүн маань өөрөө горимын санал гаргасан. Дараа ахиад хураалгачихъя аа өнөөдрийн саналаар хураалтыг хойшлуулчихъя аа гээд. Тэгээд энэ ажлын хэсэгт орох гэж байгаа хүн нь өөрөө санал хураалтаа хойшлуулчихъя аа гэж байхад энд ингээд хүчээр хураалгаад байх нь зохисгүй байх гэж бодож байна. Тэгээд энийг нь хойшлуулчихъя гэсэн ийм саналтай.

Х.Ганхуяг: Одоо ер нь өнөөдөр Ганбаатар гишүүнээ бид нар нөгөө Төсвийн хүрээгээ хэлэлцэж чадахгүй байгаа асуудал нь юу юм гэхээр одоо төсвийн ажлын хэсэг нь ажлаа хийх хэрэгтэй байна. Төсвөө боогоод тэгээд тэр саналын томьёоллууд нь гараад бид нар хаанаас нь юу хөдлөх вэ тэгээд тодорхой болсны дараагаар ингээд бүх юм чинь төсөв нь одоо ингээд 7 хоногоор, 10 хоногоор

хойшилчихсон явж байгаа байхгүй юу. Бид нар хоцроод байгаа юм. Тэгэхээр өнөөдөр нэг талдаа гараад санал хураалтаа ч явуулаад дуусгамаар байна. Тэгээд өнөөдрөөс ажлын хэсэг нь хуралдмаар байна. Сольё гэнэ ээ.

Нууц санал хураалтад бэлдсэн бол. Тийм санал хураалт явагдсаны дараа л над дээр гар дээр ирсэн. Үгүй ээ үгүй одоо танай юунаас ч ирсэн бичгийн дагуу ингэж танилцуулагдаад байна. Одоо уншиж өгье.

Тийм, Батбаяр гишүүнийг хасаад Туваан гишүүн ингээд нэг санал хураалт явагдана гэсэн. Мөнхтулга гишүүнийг хасаад Түвшин гишүүн 2 дахь санал хураалт явагдана гэсэн үг. Ганбаатар гишүүнийг хасаад Баатархүү гишүүн. Баатархүү гэсэн байна. Даваагийн Цогтбаатарыг хасаад Бейсен гишүүн гэсэн байна. Үгүй үгүй одоо тэгээд Байнгын хорооны гишүүдийн саналаар л явна шүү дээ. Санал хураалтад бэлдээрэй.

Тус бүр дээр нууцаар хураана. Төхөөрөмжөөр хураана. Нэрс гарахгүй гэсэн үг. Санал хураалтад бэлдье.

Алив санал хураалт яасан байна? Гишүүд ирцдээ орохгүй бол. Алтанхуяг гишүүн энд төхөөрөмждөө хуруугаа уншуулмаар байна. Далайн Батбаяр төхөөрөмждөө уншуулмаар байна. Үгүй үгүй одоо уншиж өгнө шүү дээ. Тийм нэг нэг хүнээр нь хураана гэсэн үг. Мөнхтулга гишүүн юундаа ормоор байна. Ганбаатар гишүүн ормоор байна. Сайнзориг, Чойжилсүрэн гишүүн хуруугаа уншуулмаар байна. Чойжоо ах ороогүй байна шүү. Бакир байна уу? Орчихлоо. Ганзориг гишүүн ирсэн юм уу? Ирээгүй байна. Пүрэвдаваа, Мэндсайхан санал хураалтад бэлдье.

Төсвийн байнгын хорооноос байгуулах 2026 оны төсвийн ажлын хэсэг шүү эхнийх нь.

Төсвийн ажлын хэсэг дээр Далайн Батбаяр гишүүнийг хасаад Туваан гишүүнийг санал болгосон байна. Одоо эхний хүн дээрээ санал хураалт явуулъя. Санал хураалт. Далайн Батбаяр гишүүнийг хасаад оронд нь Туваан гишүүнийг санал болгосон байна. Санал хураалтад бэлдээрэй. Санал хураалт.

11 гишүүн татгалзсан байна. Санал дэмжигдсэнгүй.

2.Мөнхтулга гишүүнийг хасаад Б.Түвшин гишүүн төсвийн ажлын хэсэг дээр шүү. Санал хураалт.

Санал дэмжигдсэнгүй.

Одоо дагасан хуулийн ажлын хэсэгт Ганбаатар гишүүн нэрээ татъя гэсэн юм уу? Ганбаатар гишүүн нэрээ татсан тул, мөн Даваагийн Цогтбаатар гишүүн нэрээ татсан тул ажлын хэсэгт Баатархүү гишүүн, Бейсен гишүүнийг нэмээд тогтоолын төслөө танилцуулчихъя. Яах юм бэ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Төсвийн байнгын хорооноос тогтоох нь:

Монгол Улсын 2026 онд төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 онд төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 онд төсвийн тухай, Эрүүл

мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүн дор байгуулсугай.

Ганхуяг, Алдаржавхлан, Далайн Батбаяр, Батболд, Жаргалсайхан Заяабал, Жангабыл, Мөнхтулга, Тэмүүлэн.

2 дугаар ажлын хэсэг.

2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Үүрийнтуяа, ажлын хэсгийн гишүүдэд Бадамсүрэн, Баясгалан, Баатархүү, Лувсанжамц, Мэндсайхан, Пүрэвдаваа, Бейсен, Энхтүвшин гишүүн нарын бүрэлдэхүүнтэй баталсугай гээд тогтоолын төслийг танилцууллаа.

Өнөөдрийн хуралдаан дууслаа.

13.43 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР